

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БОЛОВСРОЛЫН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 1484 А/231

Улаанбаатар хот

Боловсролын сургалтын байгууллагад суурилсан  
дархлаажуулах үйл ажиллагааг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэл ТУШААХ нь:

- “Боловсролын сургалтын байгууллагад суурилсан дархлаажуулалтын зохион байгуулалт, цэгийн бэлэн байдлыг хангах заавар”-ыг хавсралтаар баталсугай.
- Ерөнхий боловсролын сургуульд дархлаажуулалтын ажил зохион байгуулахад мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалт, оролцоог хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, тус тус даалгасугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар (О.Энхболд), Боловсролын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл), Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т тус тус үүрэг болгосугай.



Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын  
2024 оны 10.-р сарын 05.-ны өдрийн  
Э/484/231 тоот тушаалын хавсралт

**БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУУРИЛСАН  
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТҮР ЦЭГИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ  
ХАНГАХ ЗААВАР**

**Нэг. Зохион байгуулалт**

- 1.1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв харьяа нутаг дэвсгэрт байгаа төрийн болон төрийн бус өмчийн өрөнхий боловсролын сургууль (цаашид “сургууль” гэх) -ийн зорилтот насны хүүхдийг тодорхойлж дархлаажуулалтын төлөвлөгөө гаргах, түүний хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавих, бэлэн байдлыг хангах, удирдан зохион байгуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.2. Өрх, тосгон, сум, дүүргийн эрүүл мэндийн төв (цаашид “ЭМТ” гэх) харьяа нутаг дэвсгэрийн зорилтот насны хүүхэд, төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн судалгааг хамтран гаргана.
- 1.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн холбогдох байгууллагатай хамтран дархлаажуулалтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө дархлаажуулалтад хамрагдах насны хүүхдийн тоо, дархлаажуулалтын цэгийн бэлэн байдал, хүний нөөц, сургалтад хамрагдсан байдал, төлөвлөлт, хүйтэн хэлхээний чадавх зэрэгт хяналт хийнэ.

**Хоёр. Товлолын дархлаажуулалтад хамрагдах зорилтот насны хүүхдийн судалгаа**

- 2.1. Товлолын дархлаажуулалтад хамрагдах зорилтот насны бүлэгт тухайн ондоо заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу сахуу, татрангийн эсрэг дархлаажуулалтад хамрагдах 7, 15 насны хүүхэд, хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдах 11 насны хүүхдүүд тус тус байна.
- 2.2. Зорилтот насны бүлгийн хүүхдийн судалгааг анги, бүлэг, сургууль, баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэл бүрээр гаргана.
- 2.3. Товлолын дархлаажуулалтад хамрагдах зорилтот бүлгийн насны хүн амын тоог 7, 11, 15 нас тус бүрээр гаргаж тухайн оны хүн амын статистикийн мэдээлэлтэй тулган эцэслэнэ.

**Гурав. Дархлаажуулалтад оролцох хүний нөөцийн төлөвлөлт, сургалт**

- 3.1. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд хамтран зохион байгуулах сургууль, ЭМТ-ийн хүний нөөцийн судалгааг гаргана.
- 3.2. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд ажиллах хүний нөөцийн судалгаанд эрүүл мэндийн байгууллагын их эмч, бага эмч, вакцинатор, сувилагч, нийгмийн

ажилтан болон сургуулийн эмч, бусад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах хүнийг хамруулан судалгааг гаргана.

- 3.3. Дархлаажуулах зорилтот бүлгийн хүүхдийн тоо, дархлаажуулалтын цэгийн тоо, байршил, вакцины хүйтэн хэлхээний онцлог, хүний нөөцөөс хамаарч багт хуваарилан баталгаажуулж, багийн гишүүдэд танилцуулна.
- 3.4. Дархлаажуулах хүүхдийн тоогоос хамааран сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвөөс дархлаажуулалтын цэгт 1-2 баг ажиллахаар төлөвлөнө.
- 3.5. Шаардлагатай үед дайчлан ажиллах хүний нөөцөд байгаа ажилтныг татан оролцуулна.
- 3.6. Дархлаажуулалтын багийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож үүрэгжүүлнэ.
- 3.7. Сургалтын төлөвлөгөөний дагуу багийн бүх гишүүд болон дайчлагдан ажиллах багийн гишүүдийг сургалтад бүрэн хамруулна. Шаардлагатай бол давтан сургана.
- 3.8. Халдварын өвчлөл, бусад цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сургалтыг цахим эсвэл танхимын хэлбэрээр зохион байгуулна.

#### **Дөрөв. Дархлаажуулалтын цэгийн бэлэн байдлыг хангах**

- 4.1. Дархлаажуулалтын цэгийг төрийн болон төрийн бус өмчийн сургуульд түшиглэн зохион байгуулна.
- 4.2. Дархлаажуулалтын цэгийг байгуулахдаа аль болох зай талбай хангалттай, агааржуулалт, гэрэлтүүлэг сайтай хурлын заал, урлаг, спортын заал, эсхүл анги танхим ашиглана.
- 4.3. Орох, гарах хөдөлгөөний чиглэлийн тэмдэг тэмдэглэгээг хийнэ.
- 4.4. **Хүлээлгийн хэсэгт** (Орох хэсэг) сургуулийн эмч, нийгмийн ажилтан зохицуулагчаар ажиллана.
- 4.5. **Вакцинжуулах хэсэгт** бүртгэгч (эмч, сувилагч, нийгмийн ажилтан г.м), үзлэг хийх эмч, вакцинатор байрлана.
- 4.6. Өрөө нь  $2m^2$  доошгүй талбай бүхий, 3-4 тусдаа ширээтэй байна. Ширээ бүр үйл ажиллагааг илтгэсэн хаягтай байна.
- 4.7. Эхний ширээнд дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн бүртгэлийг хөтлөх хүн сууна. Хоёр дахь ширээнд хүүхдийн биед үзлэг хийх ЭМТ-ийн эмч сууна. Гурав дахь ширээнд вакцинатор/сувилагч сууж, вакцин тарина.
- 4.8. Эмчийн үзлэг, вакцин хийх хэсгийг заавал хаалтаар тусгаарлана.
- 4.9. Дархлаажуулалтын түр цэгт баримтлах тарилгын аюулгүй байдал, хүйтэн хэлхээ, хог хаягдлын холбогдох тушаал, зааврын дагуу хэрэгжүүлнэ.
- 4.10. **Ажиглалтын хэсэгт** вакцин хийлгэсэн хүүхэд 15-30 минут байх тул аль болох зай талбай хүрэлцээтэй, хангалттай өрөө, тасалгаа, орон зайд сонгож, суух сандал байрлуулж сургуулийн эмч болон дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах багш хяналт тавина.

#### **Тав. Дархлаажуулалтын багийн үүрэг:**

- 5.1 Дархлаажуулалтын баг бүр (олон нийтийн зохицуулагч, дараалал зохицуулагч, бүртгэгч, эмч, вакцинатор, ажиглагч) 4-7 гишүүнтэй байна.

- 5.2 Тухайн сургууль дархлаажуулалтын бэлэн байдлаа хангах өрөөг бэлтгэх, дэмжлэг үзүүлэн хамtran ажиллах ажлын хэсэг/ багийг томилж ажиллуулна.
- 5.3 **Олон нийтийн зохицуулагчийн үүрэг:**
- 5.3.1 Дархлаажуулалтад хамрагдах насы хүүхэд болон тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид дархлаажуулалтын талаар мэдээллийг хүргэж ажиллана. Мөн дархлаажуулалт хийгдэх төлөвлөгөөт хуваарийг таниулах ажил хийнэ.
- 5.3.2 Олон нийтийн зохицуулагчийг **сургуулийн эмч, нийгмийн ажилтан, ЭМТ-ийн эмч, нийгмийн ажилтан** хийх бөгөөд дархлаажуулалт эхлэхээс өмнө хүүхэд болон эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамtran ажиллах мэдээлэл золилцох үүргийн дагуу МЭДЭЭЛЭХ ХУУДСЫН дагуу мэдээллээр хангасан байна (*ангийн эцэг эхийн хурал, хүүхдээ авахаар ирэхэд нь уншуулж танилцсан гарын үсэг зуруулах г.м хэлбэрээр*).
- 5.3.3 Хүүхэд сарын дотор ямар нэгэн вакцинд хамрагдсан эсэхийг эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс тодруулж бүртгэлд бүртгэсэн байна.
- 5.3.4 Мэдээлэх хуудсыг ангийн багш өрхийн эрүүл мэндийн төвөөс томилогдон ажиллаж буй багийн ахлагч болох эмчид болон бүртгэгчид өгнө.
- 5.4 **Дараалал зохицуулагчийн үүрэг:**
- 5.4.1 Дараалал зохицуулагч нь сургуулийн эмч, дэмжлэг үзүүлэн хамtran ажиллах багш байна.
- 5.4.2 Дархлаажуулалтын түр цэг дээр ирсэн хүүхдийг дархлаажуулалтад урина. Дархлаажуулалт явагдаж байгаа хэсгийг эмх цэгтэй байлгаж хөдөлгөөний урсгалыг хүүхдүүдэд тайлбарлаж өгнө.
- 5.4.3 Хүүхдийг мэдээллээр хангана, тайвшруулна
- 5.5 **Бүртгэгчийн үүрэг:**
- 5.5.1 Дархлаажуулалт эхлэхийн өмнө төлөвлөгөөнд тусгасны дагуу урьдчилан бэлтгэсэн анги, бүлэг бүрийн бүртгэлийг авна
- 5.5.2 Орж ирсэн хүүхдийн овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, холбоо барих утсыг тодруулан, бүртгэлтэй тулган бүртгэлд тэмдэглэнэ.
- 5.5.3 Мэдээлэл өгөх мэдээлэх хуудсыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь танилцсан эсэхийг хянан тулгана.
- 5.6 **Ажиглагчийн үүрэг:**
- 5.6.1 Хүүхдийг вакцин хийлгэсний дараа 15-30 минут хяналт хийх өрөөнд нь байлган ажиглана.
- 5.6.2 Тарьсан газраа хөндөхгүй, маажихгүй, цохихгүй, ус хүргэхгүй, эм, тос, ариутгалын бодис зэргийг түрхэхгүй, хүйтэн зүйл уухгүй, даарахгүй байх болон бусад дархлаажуулалтын дараа анхаарах зүйлийг зөвлөнө.
- 5.6.3 Ямар нэгэн зовуурь илэрвэл багш, сургуулийн эмч, сум, өрхийн эмчид мэдэгдэхийг зөвлөнө.

#### **Зургаа. Дархлаажуулалтын түр цэгийн зохион байгуулалт**

- 6.1 Дархлаажуулалтын цэг нь вакцинжуулалтын өрөө болон хүлээлгийн, ажиглалтын хэсэгтэй, нэг чигийн урсгалтай байхаар зохион байгуулна.

- 6.2 Дархлаажуулалтын цэгийн өрөө нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, агааржуулалт сайтай, аль болох бохир, цэвэр усны төвлөрсөн шугамд холбогдсон, халаалттай байна.
- 6.3 Дархлаажуулалтын цэгт эсвэл цэгийн ойролцоо ашиглах боломжтой гар угаах угаалтуур бүхий ариун цэврийн өрөө, бие засах газартай байна.
- 6.4 Дархлаажуулалтын өрөөнд 2 цаг тутамд 10-15 минут салхивч нээж, агааржуулалт хийнэ.
- 6.5 Өдөрт 2-оос доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ хийж, цэвэрлэгээний дараа халдвартгүйжүүлэлтийг арчиж хийнэ. Гар шүршигч ашиглаж байгаа үед зайд талбай үлдээхгүй хэсэг хугацаанд чийгтэй байхаар тооцож, хангалттай хэмжээгээр шүршээд алчуураар тарааж арчина.
- 6.6 Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх зөвшөөрөлтэй бодисыг сонгож, орчны халдвартгүйжүүлэлтэд ашиглана. Түгээмэл хэрэглэдэг бодисыг дараах концентрацаар найруулж хэрэглэж болно. Үүнд: Гипохлорт натри 0.1%, 0.5%, Жавелион 0,015%, 0,003%, Хлорсепт 0,02-0,1% гэх мэт
- 6.7 Цэвэрлэгээ халдвартгүйжүүлэлт хийхдээ хамгаалах хувцас өмсөнө. Ахуйн бээлийг ажил дууссаны дараа халдвартгүйжүүлэх уусмалд дүрж халдвартгүйжүүлээд тайлна.
- 6.8 Эрүүл мэндийн ажилтанд зориулсан гар угаах угаалтуур/гар халдвартгүйжүүлэх бодис, амны хаалт, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын уут, аюулгүй хайрцагны нөөцийг бэлтгэнэ.